

ГУТАЛ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2015.10.09

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН нь:

“Гутал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2015.10.09 өдрийн 09¹⁰ минутанд “Гутал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн өрөөнд эхлэв.

Тус хуралд:

1. Б.Бүүвэй- Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн
 2. О.Буяннэмэх- Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн
 3. Т.Дарима- Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
 4. Ч.Долгормаа- Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
 5. Ц.Төмөр- Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нар тус тус биечлэн оролцохоор ирсэн.
-
1. Х.Алтай - Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн
 2. Б.Батхишиг- Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
 3. Б.Баттөр- Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн тус тус эчнээ саналтай оролцсон.

Хурлын ирц:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 9 гишүүнээс 5 гишүүн биечлэн хуралд оролцож, 3 гишүүн эчнээ саналтай, 1 гишүүн оролцоогүй байна. Хурлын ирц 88.88 хувь.

Хэлэлцэх асуудал:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргыг сонгох;
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороод байгуулах, хороодын гишүүдийг сонгох;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс Ерөнхий Захиралтай байгуулах гэрээг батлах;
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам хэлэлцэж батлах;
5. 2015.09.28-ны өдрийн Х.Алтай гишүүний өргөдлийг хэлэлцэх
6. 2013 оны 04 дугаар сарын 10-ны өдрийн Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээний 2 дугаар зүйл 2.7 заалтын дагуу “Номин реалтор” ХХК-ийн хөрөнгө оруулалтыг баталгаажуулах үүргийн дагуу санхүүгийн үнэлгээний аж ахуй нэгж, байгуулгыг сонгох ажлын хэсгийг байгуулах.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал эхлэхэд гишүүд санал нэгтгэйгээр хурал даргалагчаар Ч.Долгормааг сонгов.

СОНССОН нь:

Долгормаа: Сайн байцгаана уу. 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар надад үүрэг өгсний дагуу би ТУЗ-ийн ирцийг танилцуулья. Манай компанийн нярав, харуул албаны дарга, жолооч нар бүх гишүүдэд хурлын зарыг өгсөн. Б.Батбаяр, Б.Батхишиг нарын зарыг гарт нь хүргүүлсэн. Б.Баттөрийн зарыг Б.Батбаяр хүлээж авсан. Х.Алтайгийн зарыг Од плазагийн оффисын байранд үлдээсэн. Хариу ирүүлээгүй.

1. Б.Батбаяр дараах агуулга бүхий 2015.10.07-ны өдөр хариу ирүүлсэн. Гутал ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Ц.Төмөр, Ч.Долгормаа, Т.Даримаа нарт хаягласан байна. “Гутал ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн гэх Б.Бүүвэй, О.Буяннэмэх нартай холбоотой шүүхийн шийдвэр гартал бид ТУЗ-ийн хуралд оролцох боломжгүй гэдгийг хойшид анхаарна уу. Жич: Гутал ХК-ийн 2015 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас хойшхи хугацаа бэлэн мөнгөний зарлагын гүйлгээний тайланг өнөөдрийн байдлаар гаргаж ирүүлэхийг дахин шаардаж байна.” гэжээ.

Энэ захидалд Б. Батбаяр гарын үсэг зурсан тул өөрөө хуралд оролцох боломжгүйгээ илэрхийлж байна гэж ойлгогдож байна. Бусад гишүүдийн зүгээс ямар нэг санал захидал ирүүлээгүй. Бид хуралд ирэхийг удаа дараа урьсан байхад ирээгүй хэлэлцэх асуудлаар саналаа өгөөгүй учраас санал өгөх завгүй байгаа юм байна гэж ойлгоод хэрэв хуралд ирээгүй, санал өгөөгүй тохиолдолд хэлэлцэх асуудлыг дэмжсэнд тооцно гэсэн санамжыг бүх гишүүдэд хүргэсэн. Энэ санамжын дагуу ямар нэг татгалзал ирүүлээгүй учраас бид Б.Батхишиг, Б.Баттөр, Х.Алтай нарыг эчнээ санал авах хуудсанд дурьдсан доорх хэлэлцэх асуудлуудыг хариу ирүүлэхгүй байх замаар дэмжсэн санал өгсөн гэж үзэж байна.

- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргыг сонгох; Нэр дэвшигч О.Буяннэмэх
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороод байгуулах, хороодын гишүүдийг сонгох;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс Ерөнхий Захиралтай байгуулах гэрээг батлах;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам хэлэлцэж батлах;
- 2015.09.28-ны өдрийн Х.Алтай гишүүний өргөдлийг хэлэлцэх;
- 2013 оны 04 дугаар сарын 10-ны өдрийн Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээний 2 дугаар зүйл 2.7 заалтын дагуу “Номин реалтор” ХХК-ийн хөрөнгө оруулалтыг баталгаажуулах үүргийн дагуу санхүүгийн үнэлгээний аж ахуй нэгж, байгууллыг сонгох ажлын хэсгийг байгуулах.

Хуралд Б.Бүүвэй, О.Буяннэмэх, Т.Дарима, Ч.Долгормаа, Ц.Төмөр нар биечлэн иржээ. Иймээс хурлын ирц бүрдсэн, хүчин төгөлдөр тул хурлаа үргэлжлүүлж явах уу.

Буяннэмэх: Хурлын ирц хүрэхгүй гэдэг шалтгаанаар байнга хойшилж байсан. Өмнөх хурлуудад эчнээ саналаар саналыг авахад ирэхгүй 4 гишүүд хэлэлцэх асуудлуудыг зөвшөөрөхгүй байсан тул ирц хүрэхгүй хойшлоод байсан. Өнөөдөр нэг л гишүүн татгалзсан, бусад 5 гишүүн биечлэн ирсэн, 3 гишүүн хариу ирүүлээгүй учраас зөвшөөрсөн гэж үзээд хурал хүчин төгөлдөр бөгөөд асуудлаа шийдээд явья.

Дарима: Тэгье. Зөвшөөрч байна.

Батбаяр: Зөвшөөрч байна.

Төмөр: Тэгье. Зөвшөөрч байна.

Долгормаа: Би өнгөрсөн хугацаанд Санхүүгийн Зохицуулах хороо, United partners ХХН, Адвокатконсалтинг ХХН-д тус тус ТУЗ-ийн асуудлаар дараах агуулга бүхий зөвлөмж хүсэх тухай хүсэлт явуулсан. Үүнд:

““Гутал” ХК-ийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөл/ТУЗ/-ийг ердийн гишүүнээр Б.Батбаяр, Б.Батхишиг, Б.Баттөр, Т.Дарима, Ч.Долгормаа, Ц.Төмөр нар, хараат бус гишүүнээр Х.Алтай, Б.Бүүвэй, О.Буяннэмэх нар нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

ТУЗ байгуулагдсанаас хойш өнөөдрийг хүртэл Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргыг сонгох, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргыг сонгох, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүдийг сонгох, Ерөнхий захирлыг сонгох, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс Ерөнхий Захиралтай байгуулах гэрээг батлах, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам хэлэлцэж батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэхээр ТУЗ-ийн ээлжит хурлыг 12 удаа зарласан боловч хуралдуулж чадахгүй байна.

Учир нь ТУЗ-ийн гишүүд болох Х.Алтай, Б.Батбаяр, Б.Батхишиг, Б.Баттөр нар хуралд ирдэггүй, ирсэн ч хурлыг орхин гардаг тул хурлын ирц хүрэхгүй шалтгаанаар ТУЗ-ийн хурал хойшилсоор байна.

Иймд “Гутал” ХК-ийн ТУЗ-ийг хуралдуулах, дээрх асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөмж өгч тусална уу.”

Уг зөвлөмжийн хариуд СЗХ 2015.09.22-ны өдөр, United partners ХХН 2015.10.07-ны өдөр, Адвокатконсалтинг ХХН 2015.10.05-ны өдөр дараах агуулга бүхий хариу ирүүлжээ.

СЗХ: “Хорооны зүгээс боломжгүйг мэдэгдэж байна”

United partners ХХН: “Хөндлөнгөөс аливаа этгээд оролцох боломжгүй, журмаараа нарийвчилж зохицуулахыг зөвлөж байна.”

Адвокатконсалтинг ХХН: “ТУЗ-ийн бүрэн эрхийн асуудал байна, хувийн хэвшлийн байгууллага оролцох нь Компанийн засаглалд сөргөөр нөлөөлөх юм.” гэжээ.

За ингээд хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэх үү.

Төмөр: Тэгье. Эдийн засгийн хямралтай байгаа үед ийнхүү тогтворгүй байгаа маань компанийн цаашдын үйл ажиллагаанд хүндрэлтэй байна. Одоо дулааны үе ирж байгаа тул компаниас гарах зардал улам ихэснэ. Үүнийг бид шийдэх, компанийн үйл ажиллагааг жигдрүүлэх шаардлага зайлшгүй гарч байна. Манай компанийн зарим ажилтнуудын цалинг өгч чадахгүйд хүрлээ. Тухайлбал хуулийн зөвлөх Д.Цэрэндоржийн 8, 9 дүгээр саруудын цалин хөлсийг өгч чадахгүй байна. Д.Цэрэндорж 2015.09.17-ны өдөр Гутал ХК-д албан шаардлага хүргүүлж, шийдэж өгөхгүй бол шүүхэд хандахаа мэдэгдсэн. Компанийн банкин дахь дансыг хаасан тул гүйлгээ хийх боломжгүй тул цалинг өгч чадахгүй байгаа. Түүнчлэн шинээр түрээсийн гэрээ байгуулах, гэрээг сунгах асуудлууд овоорч байна. Иймээс асуудлуудыг шууд шийдээд явахгүй бол хэцүү байна.

Дарима: Тэгье. Зөвшөөрч байна.

Бүүвэй: Зөвшөөрч байна.

Буяаннэмэх: Тэгье. Зөвшөөрч байна.

Долгормаа: 1 дүгээр хэлэлцэх асуудал “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргыг сонгох”. Нэр дэвшигч О.Буяаннэмэх хараат бус гишүүн байна. Санал байна уу?

Дарима: Санал байхгүй. Зөвшөөрч байна.

Бүүвэй: Зөвшөөрч байна. Компанийн засаглалын кодексээр ТУЗ-ийн даргыг хараат бус гишүүдээс сонгохыг эрмэлзэхээр зохицуулсан байдаг.

Төмөр: Дэмжиж байна.

Буяаннэмэх: Дэмжиж байна.

Долгормаа: Дэмжиж байгаа. Хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар сонгогдлоо. Баяр хүргье. 2 дугаар асуудал Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороод байгуулах, хороодын гишүүдийг сонгох;

Буяаннэмэх: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороодод гишүүд саналаа өгөөд, шийдвэрлэх ёстой байдаг. Компанийн дүрмийн дагуу 3 хороо байгуулагдах ёстой. Үүнд Х.Алтай гишүүний асуудал бас хамаатай. Х.Алтай гишүүнийг орлох этгээд түр томилсны дараа 3 хараат бус гишүүн бүрдэж байж шийдвэрлэх нь зөв.

Долгормаа: Тэгвэл дараагийн хурлаар шийдвэрлэхийг би зөвшөөрч байна.

Дарима: Зөвшөөрч байна.

Бүүвэй: Зөвшөөрч байна.

Төмөр: Дэмжиж байна.

Долгормаа: 3 дугаар асуудал “Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс Ерөнхий Захиралтай байгуулах гэрээг батлах юм. Үүнд 2014 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн “Гутал” хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс Ерөнхий захирал Ц.Төмөргэй байгуулсан гэрээний цалин, урамшуулал, хангамж зэрэг нөхцлийг хэвээр үлдээж, бусад зохицуулалтуудыг хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулж батлах саналтай байна. Та бүгд юу гэж бодож байна?”

Буяаннэмэх: Хувьцаа эзэмшигчдийн хурлын дараа нийт 5 сар нийт 12 удаа хурал зарласан. Хуралд гишүүд хүрэлцэн ирэхгүй учраас ажил ингэж хойш тавигдаад байна. Ингээд хугацаа алдахгүй Ерөнхий захирлын гэрээг батлах нь чухал байна. Би зөвшөөрч байна.

Долгормаа: Би зөвшөөрч байна.

Дарима: Зөвшөөрч байна.

Төмөр: Зөвшөөрч байна.

Бүүвэй: Дэмжиж байна.

Долгормаа: Төмөр захиралд баяр хүргье. Хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэлээ. Дараагийн асуудал бол Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам хэлэлцэж батлах байна. Төслийг танилцуулж удаж байгаа. Бид одоо батлах уу.

Буяннэмэх: Тиймээ батлая.

Дарима: Олон удаа уншиж танилцсан. Санал байхгүй. Батлая.

Төмөр: Дэмжиж байна.

Бүүвэй: Дэмжиж байна.

Долгормаа: Анхааруулахад ТУЗ-ийн гишүүд хуралд ирэхгүй бол журмын дагуу цалинг хасахаар байгаа. 5 дахь асуудал 2015.09.28-ны өдрийн Х.Алтай гишүүний өргөдлийг хэлэлцэх; Энд би нэг саналтай байна. Дараагийн хурлаар Х.Алтайг дахин хуралд уриад, түр орлох этгээдийг томилоод явах уу. Х.Алтай гишүүн цаг алдахгүй одоо чөлөөлөгдмөөр байна гэж байна.

Буяннэмэх: Тэгвэл өргөдлийг нь хүлээж аваад, Хувьцаа эзэмшигчдийн хуралд уламжлах нь зөв байх. Мөн Х.Алтай гишүүний оронд ТУЗ-ийн хараат бус гишүүнийг орлох этгээдийг дараагийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх саналтай байна. Орлох этгээдэд бусад гишүүд нэр дэвшүүлэх санал байвал ирүүлэх нь нээлттэй гэж хэлмээр байна.

Долгормаа: ТУЗ-ийн дарга та үүнийг хариуцаад авах уу.

Буяннэмэх: Тиймээ, би хариуцъя. Дахиж ТУЗ-ийн хурлаар ярилцъя. Хувьцаа эзэмшигчийн хуралд нэр дэвшиж, сонгогдоогүй 2 хүн байгаа. Үүнээс Баянмөнх гэдэг хүн Батбаяр гишүүний туслах учраас ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж байна. Ууганжаргал гэдэг хүн шаардлага хангасан гэж бодож байна. Тухайн үед нэр дэвшигч байхад шалгасан. Нэмэлтээр хүн нэр дэвшүүлж болно.

Долгормаа: ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга байхгүй байсан тул ТУЗ-д ирсэн баримт бичгийг захирал бид хоёр хүлээж аваад хадгалаад байсан. Одоо танд уламжилж өгнө.

Буяннэмэх: Тэгэлгүй яахав. Тиймээ дараагийн хурлаар мөн ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг бас томилох шаардлагатай байна. Тэгээд ТУЗ-ийн албан бичгийг хүлээн аваад хариуцана.

Дарима: Батбаяр гишүүний дураараа тамга ашиглаж, албан бичиг хэрэглэснийг яах вэ?

Буяннэмэх: Угаасаа хүчингүй байсан. Цагдаагийн байгууллага хууль бус тамга, тэмдэг ашиглаж байгаа гэдгийг шалгаж байгаа. Нийслэлийн цагдаагийн газраас хууль бус байна гэж нотолсон байгаа. Гутал ХК дүрмээрээ хоёр тамгатай байх ёсгүй юм.

Долгормаа: Сүүлийн асуудал 2013 оны 04 дугаар сарын 10-ны өдрийн Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээний 2 дугаар зүйл 2.7 заалтын дагуу “Номин реалтор” ХХК-ийн хөрөнгө оруулалтыг баталгаажуулах үүргийн дагуу санхүүгийн үнэлгээний аж ахуй нэгж, байгууллыг сонгох ажлын хэсгийг байгуулах байна. Үүнийг ТУЗ-ийн гишүүдээс яаралтай шийдэж өгнө уу гэж хүсэж байна. Өмнөх хурлаар хэрэглэний дагуу компанийн

нягтлан бодогч СЗХ-оос зөвшөөрөгдсөн бүх үнэлгээний компаниудад мэйл явуулсан. Саналаа ирүүлнэ үү гээд. Бүх компаниас хариу ирсэн. Гэхдээ тэдэн төгрөгний ажил гэж нарийн хэлээгүй. Нягтлан бодогч ийм тайлбар тавьж байна. Би өөрөө ганцаараа хийхгүй. ТУЗ шийдэх ёстой гэж байна. Тиймээс ТУЗ-өөс санхүүгийн мэдлэгтэй 2 хүний ажлын хэсэг байгуулвал яасан вэ гэсэн саналтай байна.

Буяннэмэх: Хөрөнгө оруулах асуудалд холбогдуулан санхүүгийн үнэлгээний аж ахуй нэгж, байгууллагыг судлах шаардлагатай. Үүнийг Ерөнхий захирал маань судалж, дараагийн хуралд саналаа оруулж ирүүлмээр байна. Тэгээд ТУЗ батлаад явъя.

Долгормаа: Тэгвэл Ерөнхий захирал, нягтлан бодогчтойгоо хамт судлаад оруулж ирэх юм байна.

Дарима: Номингоос ирүүлсэн жагсаалт нь бодитоор хийгдсэн үү, үгүй юу гэдгийг тогтоолгох нь зөв.

Төмөр: Энэ их хэмжээний мөнгөний асуудал л даа. Үүнийг мэргэжлийн сайн компаниар хийлгүүлэх шаардлагатай.

Долгормаа: Захирал үйл ажиллагааны төлөвлөгөөгөө ТУЗ-д танилцуулж батлуулах нь зөв байх. Учир нь компанийн дотоод асуудлаас эхлээд ажил их байна.

Буяннэмэх: Тэр бол нээлттэй. Хэлэлцэж шийдэх асуудлыг тухайн хурал дээр ярилцаад явъя.

Долгормаа: Дараагийн хурлыг хэзээ хийх үү?

Буяннэмэх: Дараагийн хурлыг дараагийн баасан гариг буюу 2015.10.16-ны өдөр өглөөний 9 цагаас болгох уу? дэмжиж байна уу?

Дарима: Дэмжиж байна.

Бүүвэй: Дэмжиж байна.

Долгормаа: Дэмжиж байна.

Төмөр: Дэмжиж байна.

Буяннэмэх: Өнөөдрийн хурлын тогтоолыг танилцуулья.

Бүүвэй: Хаан банкнаас гүйлгээний данс хаасан асуудлыг нэмж дараагийн хуралд хэлэлцэх нь зөв.

Долгормаа: Би үүнд тайлбар хийе. 2015.10.07-ны өдөр Монгол банкинд гомдол гаргасан. Хаан банкны хариуцлагагүй үйлдлийг шалгуулахыг хүссэн юм. Хаан банкаас данс хаасан нь буруу, УБЕГ-ын хуулийн этгээдийн бүртгэлийн газраас ирүүлсэн лавлагааны дагуу Ц.Төмөр захирал хэвээр байгаа гэж тайлбар өгсөн. Өчигдөр Хаан банкнаас залгасан. Одоо уулзах байх.

Буяннэмэх: Бид бас өнөөдрийн хурлын шийдвэрийн талаар баримт бичиг явуулж болно. Шийдвэрүүдийг хавсаргаж өгнө. Мөн Хаан банкинд хүүгийн асуудлыг бас ярих ёстой.

Долгормаа: Нэг санал байна. ТУЗ-ийн хуурамч тамгыг шүүхээр хураалгахаар шүүхэд хандах нь зөв гэж бодож байна. Тэгэхгүй бол таныг ТУЗ-ийн даргаар сонгосныг зөвшөөрөх үү, үгүй юу гэдэг асуудал гарна.

Дарима: Тиймээ, харилцагч нарт бас хэцүү.

Буяннэмэх: Одоо харилцагч байгууллагад залруулга явуулья гэж бодож байна.

Дарима: Зарлагын асуудлыг шийдэхгүй бол дулааны улирал эхэлж байна, бэлэн мөнгө шаардлагатай гэх мэт асуудалд орно.

Долгормаа: Өнгөрсөн долоо хоногт усаа хаалгах шахсан. Асуудал хүнд байна.

Буяннэмэх: За тогтоолоо танилцуулья. “Гутал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол 2015.10.09 Улаанбаатар хот, Монгол Улсын Компанийн тухайхуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, “Гутал” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.34 дэх заалт, Компанийн Засаглалын Кодексийн 5.2.5 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр Гутал ХК-д ирүүлсэн “Компанийн дотоод асуудалд хорооны зүгээс оролцохгүй” гэсэн агуулга бүхий албан бичиг, 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн United Partners ХХН, 2015 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн Адвокатконсалтинг ХХН-өөс тус тус ирүүлсэн “Хөндлөнгөөс аливаа гуравдагч этгээд оролцох боломжгүй, дотооддоо шийдвэрлэж зохицуулах нь зүйтэй” гэсэн агуулга бүхий хариу, 2015 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, компанийн өнөөгийн санхүүгийн байдал, хамтран ажилладаг байгууллагуудын албан шаардлага, итгэлцэл зэрэг нөхцөл байдлыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар О.Буяннэмэхийг сонгосугай.
2. Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод байгуулах, хороодын гишүүдийг сонгох асуудлыг зохион байгуулж, дараагийн хуралд хэлэлцүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.
3. Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөс ерөнхий захиралтай байгуулах гэрээг Ц.Төмөртэй 2014 оны 7 дугаар сарын 4-ний өдөр байгуулсан гэрээний цалин, урамшуулал, хангамжийн нөхцлийг хэвээр, бусад нөхцөлийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, сунгасугай.
4. Гутал ХК-ийн ТУЗ-ийн зүгээс 2014 оны 7 дугаар сарын 4-ний өдөр байгуулсан Төлөөлөн удирдах зөвлөлөөс Ерөнхий захиралтай байгуулах гэрээг дуусгавар болох тухай шийдвэр гаргаагүй болохыг дурьдсугай.

Түүнчлэн хэлэлцсэн асуудал болгонд тусдаа тогтоол гаргахаар шийдвэрлэв. Тогтоолтой холбоотой санал байна уу.

Төмөр: Байхгүй.

Дарима: Байхгүй байна.

Долгормаа: Байхгүй байна.

Бүүвэй: Байхгүй.

Буяаннэмэх: Хуралд хүрэлцэн ирсэн бүх гишүүдэд баярлалаа. Дашрамд хэлэхэд хэрэв хуралд ирээгүй, санал өгөөгүй Б.Батхишиг, Б.Баттөр, Х.Алтай нарыг хэлэлцэх асуудлыг дэмжсэнд тооцно гэсэн санамжыг бүх гишүүдэд хүргэсэн тул бүх асуудлыг дэмжсэн гэж санал хурааж шийдвэрлэсэн болно. За, баярлалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН:

Дараах шийдвэрийг ТУЗ-ийн хурлаар гаргав. Үүнд:

1. Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар О.Буяаннэмэхийг сонгов.
2. Гутал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод байгуулах, хороодын гишүүдийг сонгох асуудлыг зохион байгуулж, дараагийн хуралд хэлэлцүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгов.
3. Гутал ХК-ийн ТУЗ-ийн зүгээс 2014 оны 7 дугаар сарын 4-ний өдөр байгуулсан Төлөөлөн удирдах зөвлөлөөс Ерөнхий захиралтай байгуулах гэрээг дуусгавар болох тухай шийдвэр гаргаагүй ба Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөс Ерөнхий захиралтай байгуулах гэрээг Ц.Төмөртэй 2014 оны 7 дугаар сарын 4-ний өдөр байгуулсан гэрээний цалин, урамшуулал, хангамжийн нөхцлийг хэвээр, бусад нөхцөлийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, сунгав.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг хавсралт ёсоор баталсугай.
5. ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Алтайгийн 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн “хараат бус гишүүнээс чөлөөлөгдөх тухай” өргөдлийг Төлөөлөн удирдах зөвлөл хүлээн авч, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр уламжилж, хууль заасан журмын дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас нөхөн томилтол орлох этгээдийг ТУЗ-ийн дараагийн хурлаар хэлэлцэхээр шийдвэрлэхээр болов.
6. “Номин реалтор” ХХК-ийн түрээсийн зүйлд оруулсан хөрөнгө оруулалтыг баталгаажуулах үүргийн дагуу санхүүгийн үнэлгээний аж ахуй нэгж, байгууллагыг судлаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн дараагийн хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал /Ц.Төмөр/-д үүрэг болгов.
7. “Гутал”ХКомпанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын хэлэлцэх асуудлыг дараах байдлаар тогтов.
 - Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороод байгуулах, хороодын гишүүдийг сонгох;
 - Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох;
 - Чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн тус бүр нэр дэвшүүлэх, түүнийг түр томилох;
 - “Номин реалтор” ХХК-ийн түрээсийн зүйлд оруулсан хөрөнгө оруулалтыг баталгаажуулах үүргийн дагуу санхүүгийн үнэлгээний аж ахуй нэгж, байгууллагыг сонгох;

- Ерөнхий захирал үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулах;
 - Бусад шаардлагатай асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Ерөнхий захирал оруулж ирэхийг зөвшөөрсүгэй.
8. Хэлэлцсэн асуудал тус бүрт “Гутал” ХКомпанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
 9. “Гутал” ХКомпанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дараагийн хурал 2015 оны 10 дугаар сарын 16-ны өдөр 09⁰⁰хуралдуулахаар болж, харин хуралд ирэх боломжгүй гишүүд эчнээ саналаар хураалтаар санал авахаар тогтов.
 10. Дараагийн хурлын бэлтгэлийг хангах, хэлэлцэх асуудлыг ТУЗ-ийн гишүүдэд шуудан, цахим шуудангаар хүргүүлэхийг ТУЗ-ийн дарга О.Буяннэмэхэд хариуцуулав.

ТУЗ-ийн хурал 9⁵⁷ цагт дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

А.ГУЛИМ

ХЯНАСАН:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

Х.АЛТАЙ /Эчнээ саналаар/

Б.БАТТӨР /Эчнээ саналаар/

Б.БАТХИШИГ /Эчнээ саналаар/



Б.БҮҮВЭЙ

О.БУЯННЭМЭХ

Т.ДАРИМА

Ч.ДОЛГОРМАА

Ц.ТӨМӨР